

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

№ 24/40

Улаанбаатар хот

**Чанаргүй болон муу активыг
зээлийн эрсдэлийн сангаас
хорогдуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 998 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас гаргасан саналыг үндэслэн **557,818,948** (таван зуун тавин долоон сая найман зуун арван найман мянга есөн зуун дөчин найман) төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдсон **73,688,331** (далан гурван сая зургаан зуун наян найман мянга гурван зуун гучин нэгэн) төгрөгийн төлөгдөөгүй шимтгэл болон хүүгийн авлагын төлбөрийн хамт Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох лууль, тогтоомж болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааны гүйцэтгэлийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

№ 24/41

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийг акталж,
данснаас хасах, худалдан борлуулахыг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.12, 9.6.23 дахь заалт, Компанийн Үндсэн хөрөнгө, бараа материалын журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан үндсэн хөрөнгүүдийг болон элэгдэл тооцож дуусаагүй боловч ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт **6,692,802.88** (зургаан сая зургаан зуун ерэн хоёр мянга найман зуун хоёр) төгрөгийн үлдэх өртөг бүхий энэхүү тогтоолын Хавсралт №2-т заасан үндсэн хөрөнгүүдийг тус тус акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Ашиглалтын шаардлага хангаж буй боловч шинэ оффисын тохижилт, суудлын төлөвлөлттэй холбогдуулан ашиглагдахгүй болсон нийт **45,873,690.58** (дөчин таван сая найман зуун далан гурван мянга зургаан зуун ерэн) төгрөгийн үлдэх өртөг бүхий энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасан үндсэн хөрөнгийг акталж, худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үндсэн хөрөнгийн комиссын хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгүүдийг акталж, данснаас хасах буюу нягтлан бодох бүртгэлд зохих өөрчлөлт оруулах, худалдан борлуулж, олсон орлогыг Компанийн дансанд төвлөрүүлэх зэрэг ажлыг холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм журамд заасны дагуу зохион байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

№ 24/42

Улаанбаатар хот

**Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээг
шинэчлэн авах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээний “нэмэлт өөрчлөлтийн бүртгэл” хэсэг дүүрч, Компанийн мэдээлэлд шинээр нэмэлт өөрчлөлт оруулах боломжгүй болж буйтай холбоотойгоор Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авахтай холбогдуулан Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, тийнхүү бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Хууль, хянан нийцүүлэлтийн алба (Б.Оюунболд , Х.Хулан)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

№ 24/43

Улаанбаатар хот

“ЛэндМН СМЭ ББСБ” ХХК-ийн эрх мэдлийн хуваарилалтыг тодорхойлох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.11, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 24/14 тоот тогтоолын дагуу Компанийн “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг жижиг, дунд үйлдвэрлэгчдэд санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийн зорилгуудыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж тогтвортой санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлэх зорилгоор “ЛэндМН СМЭ ББСБ” ХХК (“Охин компани”)-ийг үүсгэн байгуулсныг дурдсугай.
2. Компанийн ТУЗ-ийн зүгээс Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх этгээдээр Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-ыг томилсон бөгөөд Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр) нь тус бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж буйг тэмдэглэсүгэй.
3. Компанийн ТУЗ-ийн зүгээс Охин компанийн үйл ажиллагааг төвлөрсөн удирдлагаар хангаж, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх үүднээс:
 - Охин компанийн үйл ажиллагаанд тасралтгүй, үр дүнтэй хяналт тавих;
 - Компанийн хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах;
 - Урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээх;
 - засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг тухай бүр нэвтрүүлэх;

шаардлага буйг харгалзан Охин компанийн эрх мэдлийн хуваарилалтыг энэхүү тогтоолын Хавсралтад заасны дагуу баталсугай.

4. Энэхүү тогтоолын Хавсралтаар баталсан Охин компанийн эрх мэдлийн хуваарилалтыг үндэслэн шаардлагатай бол Компанийн холбогдох баримт бичгүүдэд зохих өөрчлөлт хийхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

№ 24/43

Улаанбаатар хот

5. Цаашид Охин компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэн ажиллахдаа энэхүү тогтоолын Хавсралтаар баталсан эрх мэдлийн хуваарилалтад заасан асуудлыг тухай бүр Компанийн ТУЗ-д танилцуулж, зөвшөөрөл авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
6. Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой бусад аливаа шийдвэр, үйл ажиллагааг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай

